



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025. 12. 26 № ЗГ-1/145

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



[Signature] **Г.ЗАНДАНШАТАР**



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.12.19 № ХЭГ/ЗСҮЗ
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 89 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ


000255019553

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“4.ХЭЛЭЛЦСЭН нь: “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР




**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.12.05. № 1/2593
танай 2025.12.01-ны № 01/8863 -т

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР
ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-д заасны дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

154803339 А5.файл.2025



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2025.12.11 № 01/5879
танай 2025.12.01 -ны № 01/3865 -т


**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД Т.АУБАКИР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.



Б.БАТЦЭЦЭГ

115052773



၆.၆.၂၀၂၀

132250340

တရားရုံး အတွင်း အမှုအရာများကို စီစဉ် ဆောင်ရွက်ရန်
အောက်ဖော်ပြပါ အချက်များကို အခြေခံ၍ အမှုအရာများကို
ဆောင်ရွက်ရန် အမိန့်ချပါသည်။
• ၆-၄ အမိန့်ချပါသည်။
အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို ၂၀ နှစ်အတွင်း
အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို ၂၀ နှစ်အတွင်း

၄.၂၀၂၀ ခုနှစ်

အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို

အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို

၄.၂၀၂၀ ခုနှစ်

၄.၂၀၂၀ ခုနှစ်

အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို

အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို

အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို

အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို

အမှုအရာများကို အခြေခံ၍ အမှုအရာများကို

၄.၂၀၂၀ ခုနှစ်



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn


2025.12.05 № 01/10643

танай _____-ны № 01/3866-т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР ТАНАА


“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761002280



...
 ...
 «...» - ...

...

...
 ...

...

...



...
 ...

...
 ...
 ...
 ...
 ...



2025 оны /0/ сарын /8/-ний өдөр

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.1-д "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ" гэж, "Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ" гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.6-д "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах" зорилт дэвшүүлсэн.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас соёрхон батлах олон улсын гэрээ юм.

1.2.Практик шаардлага

Одоогийн байдлаар Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Чех Улс гэсэн 6 улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг байгуулан соёрхон баталж, иргэдийн шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох, уг хугацаанд ногдох тэтгэвэр тогтоолгон авах, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах нөхцөлийг бүрдүүлсэн.

Түүнчлэн дэлхий нийтээр шилжин суурьшигч иргэд, тэдний гэр бүлийн гишүүдийн нийгмийн хамгааллын эрхийг хангах, тухайн улсын иргэдийн адил харилцан тэгш эрх, үүрэгтэй байх, хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдаж шимтгэл төлөхөөс зайлсхийх хамгийн үр дүнтэй арга хэрэгсэл болох хоёр талт (олон талт) нийгмийн хамгааллын олон улсын гэрээ хэлэлцээр (гэрээ)-ийг байгуулан дээрх асуудлыг шийдвэрлэж байна.

Үндэсний статистикийн хороо, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас 2023 онд хамтран хийсэн “Монгол Улсын иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө” судалгаанаас үзэхэд 57.9 мянган өрхийн 106.5 мянган иргэний 44.3 хувь нь ажиллахаар, 35.9 хувь нь суралцахаар гадаад улсыг зорьсон байна. Эдгээр иргэдийн 53.9 хувь нь эмэгтэй, 40.8 хувь нь 20-34 насныхан, дунджаар 7.2 жил гадаад улсад амьдарч байна.

Гадаад улсад шилжин суурьшигч хөдөлмөрийн насны иргэд тухайн улсын эдийн засагт хувь нэмрээ оруулж байгаа боловч нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдахад иргэний харьяаллын шаардлага, хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж авах хугацааны нөхцөл хангахгүйн улмаас нийгмийн хамгааллын баталгаа нь алдагдах, мөн тухайн улс болон өөрийн улсдаа нийгмийн даатгалын шимтгэлийг давхар төлж санхүүгийн ачаалалд орох зэрэг бэрхшээл тулгарч байна.

Гадаад харилцааны яамны 2024 оны мэдээллээр Бүгд Найрамдах Австри Улсад Монгол Улсын 2,668 иргэн оршин сууж байгаагаас 1,696 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны мэдээллээр Монгол Улсад Бүгд Найрамдах Австри Улсын 30 орчим иргэн оршин сууж байна. Цаашид иргэдийн зорчих хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан энэ тоо өсөх хандлагатай байна.

Дээрх хууль зүйн болон практик шаардлагад үндэслэн гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах, эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын хэлэлцээрийг байгуулах шаардлага үүссэн.

Иймд Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсад ажиллаж, амьдарч байсан болон одоо ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын эрхийг хангах зорилгоор хоёр улсын Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн яамд 2023 оноос хамтран ажиллаж, 4 удаагийн хэлэлцээ хийснээр “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн боловсруулсан.

Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжиж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 92 дугаар захирамжаар Хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад олгосон. Хэлэлцээрт Бүгд Найрамдах Австри Улсын Ерөнхийлөгч Александр Ван дер Беллен Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын хүрээнд Улаанбаатар хотноо 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Бүгд Найрамдах Австри Улсын Европ, олон улсын харилцааны яамны Ерөнхий нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээрээр иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, хоёр улсад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны,

тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг тогтоолгон авах харилцааг зохицуулсан.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь нэг зүйлтэй ба Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүй үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;

Хуулийн төсөл батлагдаж, хэлэлцээр хэрэгжсэнээр дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

1.Хэлэлцэн тохиролцогч талуудын нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэвэр хамаарах;

2.Хэлэлцэн тохиролцогч 2 талд ажиллаж, даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж, тэтгэврийн эрх үүсгэх;

3.Хэлэлцэн тохиролцогч 2 талд даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг авах боломж бүрдэж тухайн хүний ирээдүйн нийгмийн хамгааллын баталгаа нь сайжирна.

Хоёр улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоож олгох тул Монгол Улсын Нийгмийн даатгалын санд санхүүгийн дарамт үүсэхгүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.

Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хууль батлагдсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

--- оОо ---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар нь хилийн чанадад оршин сууж байгаа иргэдийнхээ нийгмийн баталгааг хангах зорилгоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.1-т "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ" гэж, мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.6-д "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах" зорилт дэвшүүлсэн.

Энэ хүрээнд Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Бүгд Найрамдах Австри Улсын Нийгмийн хэрэг, эрүүл мэнд, асрахуй, хэрэглэгчийг хамгаалах яам 2023 оноос хамтран ажиллаж, Олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу "Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг эцэслэн тохиролцож, талуудын дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар "Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-т 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээ юм. Хэлэлцээрийг монгол, англи болон герман хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж, бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байхаар тусгасан.

Бүгд Найрамдах Австри Улс нь Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын шаардлагыг 2025 оны 07 дугаар сарын 17-ны өдөр хангасан талаар мэдээлсэн болно.

Уг хэлэлцээр хэрэгжсэнээр иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, хоёр улсад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдсэнээр тухайн хүний ирээдүйн нийгмийн баталгаа нь сайжрах юм.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно.

--oOo--

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн тухай

Дэлхий нийтээр шилжин суурьшигч иргэд, тэдний гэр бүлийн нийгмийн хамгааллын эрхийг хангах, тухайн улсын иргэдийн адил харилцан тэгш эрх, үүрэгтэй байх, хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдаж шимтгэл төлөхөөс сэргийлэх зорилгоор улс орнууд нийгмийн хамгааллын олон улсын гэрээ, хэлэлцээрийг байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газар нь хилийн чанадад оршин сууж байгаа иргэдийнхээ нийгмийн баталгааг хангах зорилгоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.1-т "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ" гэж, мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.6-д "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах" зорилт дэвшүүлсэн.

Энэ хүрээнд Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс болон Бүгд Найрамдах Чех Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулан, иргэдийн шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоох эрх үүсгэх, шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг харилцан шилжүүлэх, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж олгох талаар харилцан тохиролцон, хэрэгжүүлж байна.

Хамгийн сүүлд "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль"-ийг Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр баталсан. Түүнчлэн, Бүгд Найрамдах Австри Улстай байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээрийг соёрхон батлуулахаар, Австралийн Холбоотой Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр шинээр байгуулахаар, Оросын Холбооны Улстай байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинэчлэхээр тус тус ажиллаж байна.

Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Бүгд Найрамдах Австри Улсын Нийгмийн хэрэг, эрүүл мэнд, асрахуй, хэрэглэгчийг хамгаалах яам 2023 оноос хамтран ажиллаж, Олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу "Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг эцэслэн тохиролцож, талуудын дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан. "Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-т Бүгд Найрамдах Австри Улсын Ерөнхийлөгч Александр Ван дер Беллен Монгол Улсад төрийн айлчлалын хүрээнд талууд 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан.

Гадаад харилцааны яамны 2024 оны мэдээллээр Бүгд Найрамдах Австри Улсад Монгол Улсын 2,668 иргэн оршин сууж байгаагаас 1,696 иргэн ажил хөдөлмөр

эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны мэдээллээр Монгол Улсад БНАУ-ын 30 орчим иргэн оршин сууж байна.

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл нь 5 бүлэг, 26 зүйлтэй бөгөөд хоёр улсын иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, тэтгэвэр тогтоож олгоход дараах зарчмыг баримтлахаар тохиролцсон. Үүнд:

- Хэлэлцэн тохиролцогч талуудын нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэвэр хамаарах;
- Хэлэлцэн тохиролцогч 2 талын хууль тогтоомжийн дагуу хоёр улсад даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож, тэтгэврийн эрх үүсгэх;
- Хэлэлцэн тохиролцогч 2 талд даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг олгох.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээ юм. Хэлэлцээрийг монгол, англи болон герман хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж, бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байхаар тусгасан.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл нь нэг зүйлтэй ба “1 дүгээр зүйл. Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хооронд 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.” гэж заасан.

Хуулийн төсөл батлагдаж, хэлэлцээр хэрэгжсэнээр иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, хоёр улсад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдсэнээр тухайн хүний ирээдүйн нийгмийн баталгаа нь сайжрах юм.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хооронд 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг



**НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ
МОНГОЛ УЛС
БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс (цаашид “Хэлэлцэн тохиролцогч талууд” гэх) хоорондын нийгмийн хамгааллын салбар дахь харилцааг зохицуулах зорилгоор дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

**I БҮЛЭГ
ЕРӨНХИЙ ЗААЛТ**

**1 дүгээр зүйл
Нэр томьёо**

1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд:

- а) **“хууль тогтоомж”** гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан нийгмийн хамгааллын салбарыг зохицуулдаг хууль болон бусад эрх зүйн актыг ойлгоно;
- б) **“иргэн”** гэж Монгол Улсын тухайд Монгол Улсын иргэн, Бүгд Найрамдах Австри Улсын тухайд Бүгд Найрамдах Австри Улсын иргэнийг ойлгоно;
- в) **“эрх бүхий этгээд”** гэж Монгол Улсын тухайд нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн сайдыг, Бүгд Найрамдах Австри Улсын тухайд Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Холбооны сайд нарыг ойлгоно;
- г) **“эрх бүхий байгууллага”** гэж Монгол Улсын тухайд энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагыг болон
Бүгд Найрамдах Австри Улсын тухайд 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийг бүрэн, эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлэх үүрэг бүхий институт, агентлаг, байгууллага, эсхүл холбогдох бусад байгууллагыг ойлгоно;

289-1
**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН**

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 11 оны 12 дугаар сарын 15

д) “даатгуулсан хугацаа” гэж Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн, эсхүл даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааг ойлгоно;

е) “тэтгэмж” гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэвэр, эсхүл нэмэлт, эсхүл бусад нэмэгдэл мөнгөн тэтгэмжийг ойлгоно.

1. Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн г) заалтад заасан эрх бүхий байгууллагууд өөрчлөгдвөл Хэлэлцээрт өөрчлөлт оруулах шаардлагагүйгээр эрх бүхий этгээдүүд харилцан бичгээр мэдэгдэнэ.
2. Энэхүү Хэлэлцээрт тодорхойлоогүй аливаа нэр томъёог тухайн Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

2 дугаар зүйл Хамрах хүрээ

1. Энэхүү Хэлэлцээрт дараах хууль тогтоомж хамаарна:

а) Монгол Улсын тухайд:

Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн асуудлаарх хууль тогтоомж;
Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн асуудлаарх хууль тогтоомж;


б) Бүгд Найрамдах Австри Улсын тухайд:

Нотариатчидын онцгой хамгааллаас бусад тэтгэврийн даатгалын асуудлаарх хууль тогтоомж;
Зөвхөн II бүлгийн тухайд, өвчний даатгал болон ослын даатгалын асуудлаарх хууль тогтоомж.

2. Энэхүү Хэлэлцээр нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг шинэчлэн найруулсан, орлуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан, дагалдан гарсан, эсхүл багцалсан аливаа хууль тогтоомжид мөн адил хамаарна.

3 дугаар зүйл Хамаарах этгээд

Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч нэг талын, эсхүл хоёр талын хууль тогтоомжид хамаарч байгаа болон хамаарч байсан, мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу тэдгээр хүмүүсээс эрх үүсэж байгаа хүмүүс энэ Хэлэлцээрт хамаарна.



4 дүгээр зүйл

Эрх тэгш хандах

1. Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэд, хамаарал бүхий хүмүүс болон тэжээгчээ алдагчдад Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү Хэлэлцэн тохиролцогч талын иргэний адил эрх тэгш хандана.
2. Бүгд Найрамдах Австри Улсын тухайд энэхүү Хэлэлцээрийн зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсэг нь (ЕС) No 883/2004 журам үйлчилдэг улсын иргэд болон Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт оршин суугаа дээрх иргэдээс эрх нь үүсэж байгаа хамаарал бүхий хүн, эсхүл тэжээгчээ алдсан хүнд хамаарна.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь нийгмийн хамгааллын салбарын байгууллагууд, холбоод болон шүүхийн захиргаан дахь даатгуулсан иргэн болон ажил олгогчийн оролцооны асуудлаарх Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн заалтад хамаарахгүй.

5 дугаар зүйл

Тэтгэмжийн гадаад дахь төлбөр

1. Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тогтоосон тэтгэмжийг тухайн хүн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суугаа, эсхүл амьдарч байгаа гэсэн үндэслэлээр бууруулах болон өөрчлөхгүй.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэмжийг Хэлэлцэн тохиролцогч хоёр талын нутаг дэвсгэрээс гадуур оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэнд Хэлэлцэн тохиролцогч хоёр талын нутаг дэвсгэрээс гадуур оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч эхний талын иргэний нэгэн адил нөхцөл, хэмжээгээр олгоно.
3. Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн тухайд энэ зүйлийн 1 дэх хэсэг нь худалдан авах чадварыг тогтвортой байлгах үүднээс олгодог нэг удаагийн мөнгөн төлбөр болон нөхөн олговрын нэмэлт төлбөрт хамаарахгүй.

Бүртгэлийн дугаар. 289-3

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын үсэг)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

2025 оны 12 дугаар сарын 15


II БҮЛЭГ ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ

6 дугаар зүйл Ерөнхий заалт

Энэхүү Хэлэлцээрийн 7 болон 8 дугаар зүйлд заасныг үндэслэн, Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгч уг ажлынхаа тухайд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид хамаарна. Тухайн ажилтны ажил олгогч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байрлаж байгаа тохиолдолд энэ заалт мөн хамаарна.

7 дугаар зүйл Тусгай заалтууд

1. Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрт 1 сараас доошгүй хугацаанд ажил олгогчид хөдөлмөр эрхэлсэн ажилтныг тухайн ажил олгогч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт тодорхой ажил гүйцэтгүүлэхээр томилсон бол энэхүү хөдөлмөрийн харилцааны тухайд, уг ажилтан Хэлэлцэн тохиролцогч эхний талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж байгаа мэтээр тухайн талын хууль тогтоомжийг мөрдлөг болгох бөгөөд ингэхдээ хөдөлмөр эрхлэх хугацаа нь 60 сараас хэтрэхгүй байна.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэр дэх ажил олгогчоос гуравдагч орны нутаг дэвсгэрт томилогдсон хүн нь тухайн гуравдагч орны нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт томилогдсон бол энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарна.
3. Томилогдсон ажилтан Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт өөр ажил олгогчтой нэмэлт хөдөлмөрийн гэрээ байгуулсан, эсхүл хувиараа хөдөлмөр эрхэлсэн бол тухайн нэмэлт хөдөлмөрийн харилцаа, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн тухайд 6 дугаар зүйл үйлчилнэ.
4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн үйлчлэлд хамаарал бүхий хүн 60 сарын хугацаанд дундаа тасарсан, мөн өмнөх томилгоо дууссанаас хойш нэг жил болоогүй бол энэ зүйл дахин хамаарахгүй.
5. Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт байрлалтай агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь энэ зорилгоор ажилтнаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт томилон ажиллуулахад 60 сарын хязгааргүйгээр энэ зүйлийн 1 дэх хэсэг үйлчилнэ.



6. Хэлэлцэн тохиролцогч нэг талын далбааг мандуулсан хөлөг онгоцонд цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж байгаа хүн Хэлэлцэн тохиролцогч тухайн талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
7. Хэлэлцэн тохиролцогч нэг талын төрийн албан хаагч, түүнтэй адилтгах албан хаагч нь түүнийг ажиллуулж байгаа төрийн байгууллагын харьяалах Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
8. Энэхүү Хэлэлцээр нь 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц, эсхүл 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцын заалтад нөлөөлөхгүй.

8 дугаар зүйл

Хэрэглэгдэх хууль тогтоомжийн заалтаас онцгой тохиолдол

Ажилтан, түүний ажил олгогч, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хүсэлтээр Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд нь зөвшилцсөний үндсэн дээр тухайн ажлын чанар, нөхцөл байдлыг харгалзан энэхүү Хэлэлцээрийн 6 болон 7 дугаар зүйлд үл хамаарах онцгой тохиолдлын талаар харилцан тохиролцож болно.

III БҮЛЭГ

ТЭТГЭМЖИЙН ТАЛААРХ ЗААЛТУУД

9 дүгээр зүйл

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох

1. Хэрэв тухайн хүн Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацаатай бол тэтгэмж авах эрхийг тодорхойлох зорилгоор шаардлагатай тохиолдолд эрх тодорхойлох Хэлэлцэн тохиролцогч тал нь эдгээр хугацааг өөрийн талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаа мэтээр нэгтгэн тооцно.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тусгай схемийн хүрээнд тодорхой мэргэжлийн төрөлд, эсхүл тухайлсан ажил, хөдөлмөр эрхлэлтэд даатгалын шимтгэл төлсөн хугацааг харгалзан тэтгэмж олгодог бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу зөвхөн ижил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд даатгалын шимтгэл төлсөн хугацааг тухайн талын хууль тогтоомжийн дагуу харгалзан үзнэ.

хөдөлмөр эрхлэлтэд
Бүртгэлийн дугаар 299-5
ХЭЛЭЛЦЭЭР
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2025 оны 12 дугаар сарын 15

3. Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь нийгмийн хамгааллын тухай ижил төрлийн хэлэлцээр байгуулсан гуравдагч улсад даатгалын шимтгэл төлсөн хугацааг зөвхөн Хэлэлцэн тохиролцогч тухайн тал нь тэтгэвэр олгох эрхийг тодорхойлох зорилгоор харгалзан үзнэ.
4. Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн төлбөрийг олгосон хугацаа нь даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг уртасгахаар заасан тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авсан хугацаагаар дээр дурдсан даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг уртасгана.

10 дугаар зүйл

Нэг жилээс доош даатгалын шимтгэл төлсөн хугацаа

Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэмж тогтоох зорилгоор харгалзан үзэж байгаа даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь 12 сараас бага бөгөөд тухайн хууль тогтоомжийн дагуу уг хугацаанд тэтгэмж олгох эрх үүсэхгүй бол Хэлэлцэн тохиролцогч тухайн талын хууль тогтоомжийн хүрээнд тэтгэмж олгогдохгүй.

11 дүгээр зүйл

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцохгүйгээр тэтгэмжийг тооцоолох

Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу энэ Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоох эрх үүсэж байвал Хэлэлцэн тохиролцогч тухайн талын эрх бүхий байгууллага нь өөрийн талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тэтгэмжийн хэмжээг тогтооно.

12 дугаар зүйл

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцсоны дараа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийг тооцоолох

1. Энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд заасныг баримтлан Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн эрх үүссэн бол эрх бүхий байгууллага нь тэтгэврийг дараах байдлаар тодорхойлно:
 - а) шимтгэл төлсөн бүх хугацааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн мэтээр тооцож, тэтгэврийн онолын хэмжээг тооцоолно;
 - б) энэ хэсгийн а) заалтад дурдсан онолын хэмжээнд үндэслэн, нийт даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас

Бүртгэлийн дугаар.

289-6

МОНГОЛ УЛСЫН
ТААГАД АХУЙЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛЬ АР ХҮҮЛЬ

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20... оны 12 дугаар сарын 15

тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийн бодит хэмжээг тодорхойлно.

2. Тэтгэврийн бодит хэмжээг тодорхойлохдоо Монгол Улсын эрх бүхий байгууллага нь зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу авсан цалин хөлс болон төлсөн шимтгэлийг харгалзан үзнэ.

13 дугаар зүйл

Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцсоны дараа Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэмжийг тооцоолох

1. Энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн хугацааг нэгтгэн тооцсоноор Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн хүрээнд тэтгэмж авах эрх үүсэж байвал Бүгд Найрамдах Австри Улсын эрх бүхий байгууллага нь Монгол Улсад төлсөн даатгалын шимтгэлийн хугацааг Европын холбооны бусад улсад даатгалын шимтгэл төлсөнтэй адилтган үзэж, тэтгэмжийн хэмжээг (ЕС) No. 883/2004 журмын дагуу тодорхойлно.
2. Тэтгэмжийг тодорхойлохдоо хүүхэд өсгөсөн хугацааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт хамааруулахгүй бөгөөд зөвхөн Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу харгалзан үзнэ.

IV БҮЛЭГ БУСАД ЗААЛТ

14 дүгээр зүйл

Эрх бүхий этгээд хоорондын хамтын ажиллагаа, захиргааны дэмжлэг

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд Удирдлагын тохиролцоог байгуулж, энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тусгана.
2. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь өөрсдийн тус тусын эрх мэдлийн хүрээнд:
 - а) энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээний талаар харилцан мэдээлэл солилцоно;
 - б) энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц хууль тогтоомжийн бүх өөрчлөлтийн талаар харилцан мэдээлнэ.

Бүртгэлийн дугаар..... 289-7
МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

20 25 оны 12 дугаар сарын 15

3. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь хоорондоо, эсхүл хамаарал бүхий хүмүүс, эсхүл тэдний хууль ёсны төлөөллүүд шууд холбогдож болно.

15 дугаар зүйл

Захиргааны болон эрх зүйн туслалцаа

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ өөрийн хууль тогтоомжоо хэрэгжүүлж байгаа мэт харилцан бие биедээ тусална. Энэхүү туслалцаа нь үнэ төлбөргүй байна.
2. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь хүлээж авсан баримт бичиг, эсхүл хүсэлтийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын албан ёсны хэл, эсхүл англи хэлээр үйлдэгдсэн гэсэн шалтгаанаар хүлээн авахаас татгалзаж болохгүй.
3. Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллага хооронд хялбар, шуурхай холбогдох харилцагч байгууллагуудыг томилно.

16 дугаар зүйл

Мэдээллийн хамгаалал

1. Шаардлагатай тохиолдолд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талууд хувь хүний мэдээллийг харилцан солилцож болно. Хувь хүний мэдээллийг харилцан солилцох болон боловсруулалт хийхдээ дотоодын холбогдох хууль тогтоомж болон мэдээлэл солилцож байгаа байгууллагуудын гаргасан нөхцөл шаардлагыг баримтална. Хувь хүний мэдээллийг автоматжуулсан болон автоматжуулаагүй аргаар боловсруулахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - а) Хувь хүний мэдээллийг хуулийн дагуу, үнэн зөв, ил тод байдлаар боловсруулна. Мэдээллийг зөвхөн энэхүү Хэлэлцээрийн хүрээнд, хууль ёсны, тодорхой зорилгод нийцүүлэн боловсруулна. Мэдээлэл нь тухайн боловсруулсан зорилгод нийцсэн, уг зорилгоос хэтрээгүй байна.
 - б) Хувь хүний мэдээллийг шилжүүлж байгаа Хэлэлцэн тохиролцогч тал бусад зорилгоор боловсруулах талаар тусгайлсан зөвшөөрөл олгоогүй бол уг мэдээллийг зөвхөн тухайн зорилгод нийцүүлэн боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалтны нэр)

(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)
20 оны 12 дугаар сарын 15

в) Хувь хүний мэдээлэл нь үнэн зөв байх бөгөөд шаардлагатай тохиолдолд шинэчлэгдэж байна. Мэдээллийг тухайн зорилгоор боловсруулахдаа хувь хүний мэдээллийн алдааг устгах, эсхүл засах бүхий л зохих арга хэмжээг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлнэ. Шилжүүлсэн хувь хүний мэдээлэл нь алдаатай, шилжүүлж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид нийцэхгүй байвал уг шилжүүлсэн байгууллага нь хүлээн авсан байгууллагад энэ талаар нэн даруй мэдэгдэнэ. Энэ тохиолдолд хүлээн авч байгаа байгууллага нь уг мэдээллийг засах, эсхүл устгах арга хэмжээг нэн даруй авна.

г) Хувь хүний мэдээллийг тухайн боловсруулагдсан зорилгод зааснаас илүүгүй хугацаанд уг мэдээллийн субъектийг таньж болохуйц хэлбэрээр хадгална.

2. Хувь хүний мэдээллийг хууль бусаар, зөвшөөрөлгүйгээр боловсруулах, санамсаргүй байдлаар алдах, устгах, гэмтээхээс хамгаалсан техникийн болон зохион байгуулалтын шаардлагатай арга хэмжээ авах замаар мэдээллийн аюулгүй байдлыг хангахуйц зохистой байдлаар боловсруулж, хадгална.

3. Шилжүүлж байгаа болон хүлээн авч байгаа байгууллага нь хувь хүний мэдээллийн шилжүүлэг бүрийг бүртгэж, тэмдэглэл хөтөлнө. Энэхүү тэмдэглэлд зорилго, агуулга, шилжүүлсэн болон хүлээн авсан хугацаа, шилжүүлсэн, хүлээн авсан байгууллагыг тусгасан байна. Хувь хүний мэдээллийг устгахад мөн адил тэмдэглэл хөтөлнө. Энэхүү тэмдэглэлийг зөвшөөрөлгүй, бусад хэлбэрээр зохисгүй ашиглахаас хамгаалах арга хэмжээг авах бөгөөд 3-аас доошгүй жилийн хугацаанд хадгална. Энэхүү тэмдэглэлийг зөвхөн мэдээлэл хамгаалах дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор ашиглана.

4. Мэдээллийн эзэн өөрийгөө баталсны үндсэн дээр хувийн мэдээллийг нь боловсруулах асуудал хариуцаж байгаа байгууллагаас уг мэдээллийг энэ Хэлэлцээрийн хүрээнд шилжүүлсэн, боловсруулсан талаар, мэдээллийн эх үүсвэр, хүлээн авагч, хүлээн авагчийн төрөл, зорилго болон хуулийн үндэслэлийн талаар мэдээлэл авах эрхтэй. Уг мэдээллийг саадгүй, үнэ төлбөргүй, ойлгомжтой хэлбэрээр олгоно.

Мөн мэдээллийн эзэн нь зөрүүтэй хувийн мэдээллээ залруулсан болон хууль бусаар боловсруулсан хувийн мэдээллийг устгасан талаарх мэдээллийг авах эрхтэй.

Улмаар мэдээллийн эзний мэдээлэл хамгаалагдах эрх нь зөрчигдсөн бол Хэлэлцэн тохиролцогч талууд уг мэдээллийн эзнийг хуулийн дагуу байгуулагдсан хараат бус шударга шүүхэд гомдол гаргах эрхээр хангах,

Бүртгэлийн дугаар...

289-9

МОНГОЛЫН

ХУУЛЬ ОЙЛ ЗОХИОН ТӨВ АРХИВ

ХУУЛЬ ОЙЛ

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын тугийн тайлал)

2024 оны 12 дугаар сарын 15

мөн мэдээллийн эзэн гомдлоо үр дүнтэйгээр шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд нөхөн төлбөр авах боломжийг эрэлхийлэх нөхцөлөөр хангагдана.

Эдгээр эрхийг баталгаажуулах нарийвчилсан дүрэм, журам нь Хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана. Энэхүү эрхийг эдлэх хүсэлт гаргасан тохиолдолд тухайн мэдээллийг боловсруулсан байгууллага нь холбогдох шийдвэр гаргахаас өмнө мэдээллийг шилжүүлсэн байгууллагад уг асуудлаар тайлбар хийх боломж олгоно.

5. Хувь хүний мэдээллийг шилжүүлсэн Хэлэлцэн тохиролцогч талын урьдчилан бичгээр олгосон зөвшөөрлөөр гуравдагч этгээдэд шилжүүлж болно. Уг зөвшөөрлийг шилжүүлсэн Хэлэлцэн тохиролцогч талын дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд олгоно. Хүлээж авсан хувь хүний мэдээллийн нууцлал хангагдсан байна.
6. Хувь хүний шилжүүлсэн мэдээллийг шилжүүлж авсан зорилгоор ашиглах шаардлагагүй болсон, эсхүл боловсруулалтын үндэслэл дуусгавар болсон даруйд устгана. Хүсэлтийг үндэслэн мэдээлэл устгасан талаар шилжүүлсэн Хэлэлцэн тохиролцогч талд мэдээлнэ.
7. Шилжүүлж байгаа эрх бүхий байгууллагын хүсэлтээр хүлээн авч байгаа эрх бүхий байгууллага нь хүлээн авсан мэдээллийн боловсруулалт, үр дүнгийн талаар мэдээлнэ.

17 дугаар зүйл

Төлбөр ба баталгаажуулалтаас чөлөөлөх

1. Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд мэдүүлсэн баримт бичиг, эсхүл гэрчилгээг бүртгэлийн хураамж, хууль ёсны дагуу төлөх төлбөр, тэмдэгтийн хураамж болон татвараас хөнгөлөх, чөлөөлөх нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомж, эсхүл энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор мэдүүлэх ижил төрлийн баримт бичиг, гэрчилгээнд мөн адил хамаарна.
2. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор мэдүүлэх бүх төрлийн мэдэгдэл, баримт бичиг болон гэрчилгээнд дипломат, эсхүл консулын эрх бүхий этгээдийн баталгаажуулалт шаардахгүй.

Бүртгэлийн дугаар.....	289-10
МОНГОЛ УЛСЫН	
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ	
ХУУЛБАР ҮНЭН	
(Албан тушаалын нэр)	
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)	
20	оны 12 дугаар сарын 15

18 дугаар зүйл

Өргөдөл, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг эрх тэгш авч үзэх

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хууль тогтоомжийн дагуу Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллагад гаргасан аливаа хүсэлт, мэдүүлэг болон давж заалдах өргөдлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллагад гаргасан хүсэлт, мэдүүлэг, давж заалдах өргөдөлтэй адилтан авч үзнэ.
2. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу гаргасан тэтгэмж авах хүсэлт нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу тухайн тэтгэмжийг авах хүсэлтийн нэгэн адилаар тооцогдоно. Хүсэлтэд Хэлэлцэн тохиолцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааны талаарх мэдээллийг тусгасан байна. Гэхдээ энэ нь хүсэлт гаргагч Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу олгох өндөр насны тэтгэврээс түдгэлзэх хүсэлтээ илэрхийлсэн бол үйлчлэхгүй.
3. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу аливаа хүсэлт, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг тухайн талын эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллагад тогтоосон хугацаанд мэдүүлдэг бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллагад мөн хугацаанд мэдүүлж болно.
4. Энэ зүйлийн 1-3 дахь хэсгийг хэрэгжүүлэх тохиолдолд хүсэлт, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг хүлээн авсан эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллага нь баримт бичгүүдийг хүлээн авсан өдрийг тусган Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

19 дүгээр зүйл

Эмнэлгийн үзлэг

Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт түр, эсхүл байнга оршин суугаа хүсэлт гаргагч, эсхүл тэтгэмж авагчийг эмнэлгийн үзлэгт хамрагдахыг шаардсан бол тухайн эрх бүхий байгууллагын хүсэлт болон зардлаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага нь оршин суугаа нутаг дэвсгэрт эмнэлгийн үзлэгийг зохион байгуулна. Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу эмнэлгийн үзлэгийг зохион байгуулах тохиолдолд түр, эсхүл байнга оршин суугаа талын эрх бүхий байгууллагын зардлаар тухайн эмнэлгийн үзлэгийг зохион байгуулна.

Бүртгэлийн дугаар. 289-11
МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2025 оны 12 дугаар сарын 15

20 дугаар зүйл Харилцаа

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд болон эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн албан ёсны хэл, эсхүл англи хэлээр харилцана.

21 дүгээр зүйл Төлбөр


1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдох тэтгэмжийн төлбөрийг Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын мөнгөн тэмдэгтээр олгож болно.
2. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдох нөхөн төлбөрийг тухайн үйлчилгээ үзүүлж байгаа Хэлэлцэн тохиролцогч талын мөнгөн тэмдэгтээр хийнэ.
3. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдох төлбөрийг тухайн төлбөр төлөх үед Хэлэлцэн тохиролцогч талуудад мөрдөгдөж байгаа дүрэм, журмын дагуу олгоно.
4. Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь нутаг дэвсгэрээс гадуур оршин суугаа хүнд аливаа төлбөр, гадаад мөнгөн шилжүүлэг, гуйвуулга, эсхүл санхүүгийн хэрэгслийг хязгаарлаж байгаа мөнгөн тэмдэгтийн хяналт, эсхүл түүнтэй адилтгасан арга хэмжээ тогтоосон бол тухайн Хэлэлцэн тохиролцогч тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суугаа энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасан хүмүүст төлбөл зохих аливаа мөнгөн төлбөрийг олгоход шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

22 дугаар зүйл Илүү болон үндэслэлгүй олгогдсон төлбөр

Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллага тэтгэмжийн илүү болон үндэслэлгүй төлбөр хийсэн тохиолдолд тухайн илүү болон үндэслэлгүй төлбөрийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу олгогдох тэтгэмжээс хасаж, тухайн эрх бүхий байгууллагын дансанд шилжүүлж болно.

23 дугаар зүйл Маргаан шийдвэрлэх

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбогдон гарсан аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.



V БҮЛЭГ
ШИЛЖИЛТИЙН БОЛОН ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

24 дүгээр зүйл
Шилжилтийн заалтууд

1. Энэхүү Хэлэлцээр нь энэ Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацааны тэтгэмжийн төлбөр олгохтой холбоотой эрхийг үүсгэхгүй.
2. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг энэ Хэлэлцээрийн дагуу эдлэх эрхийг тодорхойлоход харгалзан үзнэ.
3. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацаанд тодорхойлсон тэтгэмжийн хэмжээг Хэлэлцэн тохиролцогч талууд шинээр авч үзэхгүй.
4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн эрхтэй холбоотой бусад асуудал энэ Хэлэлцээрт хамаарах бөгөөд харин өмнө нь нэг удаагийн төлбөр авах эрх үүссэн тохиолдолд хамаарахгүй.
5. Энэхүү Хэлэлцээрийн дагуу олгох тэтгэмжийн хэмжээг энэ Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн тэтгэмж авагчийн хүсэлтээр тодорхойлно. Хэрэв хүсэлтээ энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор мэдүүлсэн бол тэтгэмжийг хүсэлт мэдүүлсэн өдрөөс, харин бусад тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн хууль тогтоомжоор тогтоосон өдрөөс тэтгэмжийг олгоно.
6. Энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө Хэлэлцэн тохиролцогч нэг талд томилогдсон хүний ажилласан хугацааг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлснээр тооцно.

25 дугаар зүйл
Үргэлжлэх хугацаа болон дуусгавар болох

1. Энэхүү Хэлэлцээр нь хугацаагүйгээр үйлчилнэ. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал нь 12 сарын өмнө бичгээр гаргасан мэдэгдлийн дагуу Хэлэлцээрийг дуусгавар болгож болно.
2. Хэлэлцээр дуусгавар болсон тохиолдолд Хэлэлцээрийн хүрээнд үүссэн бүх эрх хүчин төгөлдөр хадгалагдана.

Бүртгэлийн дугаар. 280-13
МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН


(Албан тушаалын нэр)
.....
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 25 оны 12 дугаар сарын 15

3. Хэрэв энэхүү Хэлэлцээр нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу дуусгавар болсон бол энэ Хэлэлцээр дуусгавар болохоос өмнө тэтгэмж авах хүсэлтээ мэдүүлсэн, шаардлагыг хангасан хүмүүсийн тухайд энэ Хэлэлцээрийн дагуу тэтгэмж авах эрх үүсэх, тэтгэмж авах эрх нь хэвээр хадгалагдана.

26 дугаар зүйл
Хэлэлцээр хүчин төгөлдөр болох

2. Personenbezogene Daten müssen in einer Weise verarbeitet und gespeichert werden, die eine angemessene Sicherheit der personenbezogenen Daten gewährleistet, einschließlich Schutz vor unbefugter oder unrechtmäßiger Verarbeitung und vor unbeabsichtigtem Verlust, unbeabsichtigter Zerstörung oder unbeabsichtigter Schädigung durch geeignete technische und organisatorische Maßnahmen.

3. Die übermittelnde und die empfangende Behörde sind verpflichtet, jede Übermittlung beziehungsweise jeden Empfang von Daten zu dokumentieren. Diese Dokumentation beinhaltet Zweck, Inhalt und Zeitpunkt der Übermittlung beziehungsweise des Empfangs sowie die übermittelnde und die empfangende Behörde. Sinngemäßes gilt für die Vernichtung von Daten. Die Dokumentation ist durch geeignete Vorkehrungen gegen zweckfremde Verwendung und sonstigen Missbrauch zu schützen und mindestens drei Jahre aufzubewahren. Die Dokumentation darf ausschließlich zur Kontrolle,

Бүртгэлийн дугаар. 289-35

МОНГОН УЛСЫН
ХУУЛЬ ЗАСГИЙН ГЭРЛЭГ
ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийг тайлал)

20 25 12 оны 12 дугаар сарын 15

об die maßgeblichen Rechtsvorschriften über den Datenschutz eingehalten wurden, verwendet werden.

4. Jede betroffene Person hat das Recht, bei Nachweis ihrer Identität auf Ansuchen von der für die Verarbeitung verantwortlichen Behörde in allgemein verständlicher Form, ohne unzumutbare Verzögerung und kostenlos Auskunft über die zu ihr im Rahmen dieses Abkommens übermittelten oder verarbeiteten personenbezogenen Daten, deren Herkunft, allfällige Empfänger oder Empfängerkategorien, den vorgesehenen Verarbeitungszweck und die Rechtsgrundlage zu erhalten.

Ferner hat jede betroffene Person das Recht auf Richtigstellung unrichtiger und Löschung unzulässiger Weise verarbeiteter Daten.

Die Vertragsparteien stellen darüber hinaus sicher, dass die betroffene Person sich im Falle der Verletzung ihrer Rechte auf Datenschutz mit einer wirksamen Beschwerde an ein unabhängiges und unparteiisches, auf Gesetz basierendes Gericht im Sinne des Artikel 6 Absatz 1 der Konvention zum Schutz der Menschenrechte und Grundfreiheiten (Europäische Menschenrechtskonvention) wenden kann und dass ihr die Möglichkeit eröffnet wird, effektive Abhilfe sowie gegebenenfalls einen Schadenersatzanspruch geltend zu machen.

Die Einzelheiten des Verfahrens zur Durchsetzung dieser Rechte richten sich nach dem nationalen Recht der Vertragspartei, bei der sie geltend gemacht werden. Im Falle eines Ansuchens auf Geltendmachung dieser Rechte gibt die Vertragspartei, die über die Daten verfügt, der übermittelnden Vertragspartei Gelegenheit zur Stellungnahme, bevor eine Entscheidung über das Ansuchen getroffen wird.

5. Die Übermittlung der empfangenen personenbezogenen Daten an Dritte ist nur mit der vorherigen schriftlichen Zustimmung der übermittelnden Vertragspartei zulässig. Eine solche Zustimmung darf nur erteilt werden, soweit das national anwendbare Recht der übermittelnden Vertragspartei dies erlaubt. Die empfangenen personenbezogenen Daten sind vertraulich.

6. Die übermittelten Daten sind zu löschen, wenn die Daten nicht mehr zur Erfüllung der der Übermittlung zugrundeliegenden Zwecke benötigt werden oder die Grundlage für die Verarbeitung weggefallen ist. Auf Ersuchen der übermittelnden Vertragspartei wird diese über die Löschung der Daten informiert.

7. Auf Ersuchen der übermittelnden Behörde hat die empfangende Behörde Auskunft; über jegliche Verarbeitung der empfangenen Daten einschließlich der damit erzielten Ergebnisse zu geben.

Бүртгэлийн дугаар... 289-38

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

20 25 оны 12 дугаар сарын 15

Artikel 17

Ausnahmen von Gebühren und Beglaubigungen

1. Jede in den Rechtsvorschriften eines Vertragsstaates vorgesehene Befreiung oder Ermäßigung von Steuern, Stempel-, Gerichts- oder Eintragungsgebühren für Schriftstücke oder Urkunden, die in Anwendung dieser Rechtsvorschriften vorzulegen sind, erstreckt sich auf die entsprechenden Schriftstücke und Urkunden, die in Anwendung dieses Abkommens oder der Rechtsvorschriften des anderen Vertragsstaates vorzulegen sind.

2. Urkunden, Dokumente und Schriftstücke jeglicher Art, die in Anwendung dieses Abkommens vorgelegt werden müssen, bedürfen keiner Beglaubigung durch diplomatische oder konsularische Behörden.

Artikel 18

Gleichstellung von Anträgen, Erklärungen oder Rechtsmitteln

1. Anträge, Erklärungen oder Rechtsmittel, die in Anwendung dieses Abkommens oder der Rechtsvorschriften eines Vertragsstaates bei einer zuständigen Behörde oder einem zuständigen Träger eines Vertragsstaates eingereicht werden, sind als bei einer zuständigen Behörde oder einem zuständigen Träger des anderen Vertragsstaates eingereichte Anträge, Erklärungen oder Rechtsmittel anzusehen.

2. Ein nach den Rechtsvorschriften eines Vertragsstaates gestellter Antrag auf eine Leistung gilt auch als Antrag auf eine entsprechende Leistung nach den Rechtsvorschriften des anderen Vertragsstaates, sofern der Antragsteller bei der Antragstellung Hinweise auf den möglichen Erwerb von Versicherungszeiten nach den Rechtsvorschriften des anderen Vertragsstaates gibt. Dies gilt nicht, wenn der Antragsteller ausdrücklich beantragt, dass die Feststellung einer nach den Rechtsvorschriften des anderen Vertragsstaates erworbenen Altersleistung aufgeschoben wird.

3. Anträge, Erklärungen oder Rechtsmittel, die in Anwendung der Rechtsvorschriften eines Vertragsstaates innerhalb einer bestimmten Frist bei einer zuständigen Behörde oder einem zuständigen Träger dieses Vertragsstaates einzureichen sind, können innerhalb der gleichen Frist bei der entsprechenden Behörde oder Stelle des anderen Vertragsstaates eingereicht werden.

4. In den Fällen der Absätze 1 bis 3 hat die in Anspruch genommene Behörde oder der Träger diese Anträge, Erklärungen oder Rechtsmittel unverzüglich an die entsprechende zuständige Behörde oder den Träger des anderen Vertragsstaates unter Angabe des Empfangstages des Schriftstückes zu übermitteln.

Бүртгэлийн дугаар... 289-37	
МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ ХУУЛБАР ҮНЭН	
(Албан тушаалын хэр)	
(гарын үсэг)(гарын үсгийн тайлбар)	
20 25 оны 10 дугаар сарын 18	

Artikel 19

Ärztliche Untersuchungen

Verlangt der zuständige Träger eines Vertragsstaates, dass sich ein Antragsteller oder Berechtigter, der sich im Gebiet des anderen Vertragsstaates aufhält oder dort wohnt, einer ärztlichen Untersuchung unterzieht, so ist diese auf Ersuchen dieses Trägers auf ihre Kosten von dem zuständigen Träger des anderen Vertragsstaates zu veranlassen oder durchzuführen. Im Falle medizinischer Untersuchungen, die nach den Rechtsvorschriften beider Vertragsstaaten durchzuführen sind, werden diese Untersuchungen von der Stelle des Aufenthalts- oder Wohnortes auf ihre Kosten veranlasst oder durchgeführt.

Artikel 20

Kommunikation

Für die Anwendung dieses Abkommens verwenden die zuständigen Behörden und die zuständigen Träger der Vertragsstaaten die Amtssprachen des jeweiligen Vertragsstaates oder die englische Sprache.

Artikel 21


Zahlungen

1. Die Zahlung von Leistungen nach diesem Abkommen können in der Währung jedes der beiden Vertragsstaaten erbracht werden.
2. Die in diesem Abkommen vorgesehenen Erstattungen erfolgen in der Währung des Vertragsstaates, in dem die Leistung erbracht worden ist.
3. Zahlungen nach diesem Abkommen werden nach Maßgabe der Vereinbarungen oder Praxis geleistet, die zum Zeitpunkt der Zahlung in jedem der Vertragsstaaten in diesem Bereich gelten.
4. Falls ein Vertragsstaat Maßnahmen der Währungskontrolle oder ähnliche Maßnahmen verhängt, die die Zahlung, Überweisung oder die Übertragung von Vermögen oder finanzieller Mittel für Personen beschränken, die sich außerhalb dieses Vertragsstaates befinden, so hat er unverzüglich angemessene Maßnahmen zu treffen, um die Zahlung jeglicher Beträge sicherzustellen, die nach diesem Abkommen an die in Artikel 3 bezeichneten Personen zu zahlen sind, die im anderen Vertragsstaat wohnen.

Artikel 22

Zu Unrecht geleistete Zahlungen

Hat der zuständige Träger eines Vertragsstaates eine Leistung zu Unrecht gezahlt, so kann der Betrag der zu Unrecht gezahlten Leistung von einer nach den Rechtsvorschriften des anderen Vertragsstaates geschuldeten entsprechenden Leistung einbehalten und auf das Konto dieses zuständigen Trägers überwiesen werden.



Artikel 23 Streitbeilegung

Die Streitigkeiten, die sich aus der Anwendung oder Auslegung dieses Abkommens ergeben, sollen durch Beratungen zwischen den zuständigen Behörden der Vertragsstaaten beigelegt werden.


ABSCHNITT V ÜBERGANGS- UND SCHLUSSBESTIMMUNGEN

Artikel 24 Übergangsbestimmungen

1. Dieses Abkommen begründet keinen Anspruch auf Zahlung von Leistungen für die Zeit vor seinem Inkrafttreten.
2. Für die Feststellung des Anspruches auf Leistungen nach diesem Abkommen sind auch Versicherungszeiten zu berücksichtigen, die nach den Rechtsvorschriften eines Vertragsstaates vor Inkrafttreten dieses Abkommens zurückgelegt worden sind.
3. Leistungen, die vor dem Inkrafttreten dieses Abkommens festgestellt wurden, sind in beiden Vertragsstaaten nicht neu festzustellen.
4. Soweit Absatz 1 nichts anderes bestimmt, gilt dieses Abkommen auch für Versicherungsfälle, die vor seinem Inkrafttreten eingetreten sind, soweit früher festgestellte Ansprüche nicht durch Kapitalzahlungen abgegolten worden sind.
5. Leistungen, die erst auf Grund dieses Abkommens gebühren, sind auf Antrag des Berechtigten vom Inkrafttreten dieses Abkommens an festzustellen. Wird der Antrag binnen zwei Jahren nach dem Inkrafttreten dieses Abkommens eingebracht, so sind die Leistungen vom Inkrafttreten dieses Abkommens an zu gewähren, sonst von dem Tag an, der nach den Rechtsvorschriften jedes der beiden Vertragsstaaten bestimmt ist.
6. Bei der Anwendung des Artikels 7 Absatz 1 beginnt die dort genannte Entsendezeit einer Person, die vor dem Inkrafttreten des Abkommens in den anderen Vertragsstaat entsendet wurde, mit dem Inkrafttreten des Abkommens.

Artikel 25 Vertragsdauer und Kündigung

1. Dieses Abkommen wird auf unbestimmte Zeit geschlossen. Jeder Vertragsstaat kann es unter Einhaltung einer Frist von zwölf Monaten schriftlich kündigen.
2. Im Falle der Kündigung dieses Abkommens bleiben nach diesem Abkommen erworbene Ansprüche erhalten.



3. Wird dieses Abkommen gemäß Absatz 1 gekündigt, so bleiben die Ansprüche auf die nach diesem Abkommen erworbenen Leistungen und deren Zahlung gegenüber einer Person erhalten, die vor dem Zeitpunkt der Kündigung einen Antrag auf diese Leistungen gestellt hat und die Voraussetzungen für den Anspruch auf diese Leistungen erfüllt.

Artikel 26 Inkrafttreten des Abkommens

1. Die Vertragsstaaten unterrichten einander auf diplomatischem Wege schriftlich über den Abschluss der für das Inkrafttreten dieses Abkommens erforderlichen internen Verfahren. Dieses Abkommen tritt am ersten Tag des dritten Monats, der auf den Monat des letzten Notenaustausches folgt, in Kraft.


2. ZU URKUND DESSEN haben die hierzu von ihren jeweiligen Regierungen bevollmächtigten Unterzeichneten dieses Abkommen unterzeichnet.

3. GESCHEHEN zu Ulaanbaatar am 26 Mai 2025 in zwei Urschriften in mongolischer, deutscher und englischer Sprache, wobei jeder Text in gleicher Weise authentisch ist. Im Falle unterschiedlicher Auslegung ist der englische Text maßgebend.

FÜR DIE MONGOLEI:



FÜR DIE REPUBLIK
ÖSTERREICH:



Бүртгэлийн дугаар. . . 289-40 . . .

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

2025 оны 12 дугаар сарын 15



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ. Асуудалд дүн шинжилгээ хийх

- 1.1. Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ;
- 1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд;
- 1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл;

ХОЁР. Асуудлыг шийдвэрлэх зорилго

- 2.1. Гол зорилго, зорилт

ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт

- 3.1. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоох;
- 3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
- 3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын сонгох;

ДӨРӨВ. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөний талаар

- 4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
 - 4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

- 4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

ТАВ. Зохицуулалтуудын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх

ЗУРГАА. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

ДОЛОО. Дүгнэлт, зөвлөмж

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1.1. Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ:

Дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн шилжилт, өөрчлөлтийн хүрээнд улс, бүс дамнасан хүн амын шилжих хөдөлгөөний цар хүрээ жилээс жил нэмэгдэж байна. Тухайлбал, 2020 оны байдлаар дэлхийн хүн амын 3.6 хувь буюу 281.0 сая хүн гадаад улсад шилжин суурьшин амьдарч байна. Энэ нь 1990 оноос 46 хувь, 2000 оноос 38 хувь, 2010 оноос 21 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм. Мөн 2021 онд гадаадад шилжин суурьшигч 169.0 сая хүн ажил хөдөлмөр эрхэлж байна. Үүнтэй холбоотойгоор олон улсын мөнгөн шилжүүлэг 2020 онд 128.0 тэрбум ам.доллар байсан бол 2022 онд 831.0 тэрбум ам.долларт хүрч үүнээс бага, дунд орлоготой улсууд 647.0 тэрбум ам.долларын гадаад шилжүүлэг хүлээн авчээ.¹

Монгол Улсын тухайд 2023 оны байдлаар 210.0 мянган монгол иргэн буюу нийт хүн амын 6.1 хувь нь гадаад улсад оршин сууж байгаагаас 110.0 мянга нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс 26 хувь нь Бүгд Найрамдах Солонгос Улс, 14 хувь нь АНУ, 9 хувь нь Япон Улс, 8 хувь нь Австрали Улс, 6 хувь нь Бүгд Найрамдах Чех Улс, 6 хувь нь Шведийн Вант Улс, 4 хувь нь Бүгд Найрамдах Казахстан Улс, 27 хувь нь дэлхийн бусад улс орнуудад оршин сууж байна.² Гадаад улсад оршин сууж байгаа иргэдийн 40 гаруй хувь нь тухайн улсдаа 2-5 жил, 30 хувь нь 6 ба түүнээс олон жилээр оршин сууж байгаа бол 90 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам байна.³

Түүнчлэн, Үндэсний статистикийн хороо, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас хамтран 2023 онд хийсэн "Монгол Улсын иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө" судалгаанд 57.9 мянган өрхийн 106.5 мянган иргэний 44.3 хувь нь ажиллах, 35.9 хувь нь суралцахаар гадаад улсыг зорьсон байна. Эдгээр иргэдийн 53.9 хувь нь эмэгтэй, 40.8 хувь нь 20-34 насныхан, дунджаар 7.2 жил гадаад улсад амьдарч байгаа талаар дурджээ.⁴

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.1-т "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ", "Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ" гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.6-д "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах" зорилт дэвшүүлж, гадаад улсад ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах, эрх ашгийг

¹ McAuliffe, M. and L.A. Oucho (eds.), 2024. World Migration Report 2024. International Organization for Migration (IOM), Geneva.

² Гадаад харилцааны яамны Консулын газрын мэдээлэл, 2024 он

³ "Диаспорт чиглэсэн бодлого" бодлогын суурь судалгаа, НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, 2024 он

⁴ "Монгол Улсын иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө" судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, 2023 он

хамгаалж байна. Энэ хүрээнд Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улс орнуудтай нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийг байгуулж, хэрэгжүүлж ирсэн.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс Оросын Холбооны Улс (1981 он), Бүгд Найрамдах Солонгос Улс (2006 он), Унгар Улс (2011 он), Бүгд Найрамдах Польш Улс (2018 он), Бүгд Найрамдах Турк Улс (2018 он), Бүгд Найрамдах Чех Улс (2019 он) зэрэг 6 улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулж шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох, шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэвэр тогтоох, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах талаар харилцан тохиролцон, хэлэлцээрийг хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, Бүгд Найрамдах Казахстан Улс, Австралийн Холбооны Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр шинээр байгуулах, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинэчлэх чиглэлээр тус тус хэлэлцээ хийж байна.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд:

Нийгмийн даатгалын харилцаа нь тухайн хүнийг хөдөлмөрийн зах зээлд гарснаас эхлүүлээд нас барах хүртэл урт хугацааны харилцаа тул нийгмийн олон бүлгийг хамарсан томоохон харилцаа юм. Эдгээрийг үндэслэн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг дараах байдлаар тодорхойлж байна.

Гадаад харилцааны яамны 2024 оны мэдээллээр Бүгд Найрамдах Австри Улсад Монгол Улсын 2,668 иргэн оршин сууж байгаагаас 1,696 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны мэдээллээр Монгол Улсад Бүгд Найрамдах Австри Улсын 30 орчим иргэн оршин сууж байна. Цаашид иргэдийн зорчих хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан энэ тоо өсөх хандлагатай байна.

Түүнчлэн, Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн ажилтныг Бүгд Найрамдах Австри Улсад тодорхой ажил гүйцэтгүүлэхээр томилон ажиллуулах нөхцөлд хоёр улсад нийгмийн даатгалын шимтгэлийг давхардуулан төлөх шаардлага үүсэж байна.

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл:

Хүн амын гадаад шилжих хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр эдийн засаг, нийгэмд эерэг, сөрөг үр дагаврууд үүсдэг учраас үндэсний түвшний бодлого, хөтөлбөрт гадаад шилжих хөдөлгөөнийг өөрчлөлтөд хариу үзүүлэх арга хэмжээ авах, өөрийн орны онцлогт тохирсон бодлогыг тодорхойлох, боловсруулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудал чухлаар тавигдаж байна.

Тухайлбал, улс орнууд өөрийн орны нийгэм, эдийн засаг, хүн ам, насжилт, хөдөлмөр эрхлэлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, төрийн тогтолцооны нөхцөл байдал болон бусад хүчин зүйлийн хамаарлыг судалсны үндсэн дээр нийгмийн хамгааллын бодлогоо тодорхойлж, нийгмийн даатгалын тогтолцоог бий болгон хэрэгжүүлдэг. Үүнд өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болох, мөн тухайн хүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, холбогдох зардал олгох зэргээр иргэдийнхээ нийгмийн хамгааллын баталгааг хангадаг. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1952 оны 102 дугаар Нийгмийн хамгааллын (доод хэм хэмжээний) тухай конвенцид нэгдэх, хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Шилжин суурьшигч хөдөлмөрийн насны иргэд хүлээн авагч улсынхаа эдийн засагт хувь нэмрээ оруулж байгаа боловч хүлээн авагч улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдахад иргэний харьяаллын шаардлага, тэтгэвэр, тэтгэмж авах хууль тогтоомжид заасан хугацааны нөхцөл хангахгүйд хүрч нийгмийн хамгааллын баталгаа нь алдагдах, мөн тухайн улс болон өөрийн улсдаа нийгмийн даатгалын шимтгэлийг давхар төлж санхүүгийн ачаалалд орох зэрэг бэрхшээлүүд тулгарч байна.⁵

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Дэлхий нийтээр шилжин суурьшигч иргэд, тэдний гэр бүлийн нийгмийн хамгааллын эрхийг хангах, тухайн улсын иргэдийн адил харилцан тэгш эрх, үүрэгтэй байх, хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдаж шимтгэл төлөхөөс зайлсхийх хамгийн үр дүнтэй арга хэрэгсэл болох хоёр талт (олон талт) нийгмийн хамгааллын олон улсын гэрээ хэлэлцээр (гэрээ)-ийг байгуулан дээрх асуудлыг шийдвэрлэж байна. Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрт ихэвчлэн өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийг тооцоход хэлэлцэн тохиролцогч нөгөө талд ажилласан, шимтгэл төлсөн хугацааг харгалзан үзэх, эсхүл хоёр талын нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдаж шийтгэл төлөхөөс урьдчилан сэргийлэх зэрэг зохицуулалтыг тусгадаг.

Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийг дэлхийн нийт улс орны 74 хувь нь аль нэг улстай байгуулсан буюу дэлхий даяар 645 хэлэлцээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Бүс нутгаар авч үзвэл, Европын бүх улс дор хаяж нэг олон улсын хэлэлцээр байгуулан хэрэгжүүлж байгаа бол Америк тивийн 88 хувь, Африкийн орнуудын 61 хувь, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын 43 хувь нь нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах талаар хэлэлцээр байгуулсан байна. Энэ тоо цаашид өсөх хандлагатай байна.⁶

Бүгд Найрамдах Австри Улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг сайжруулах зорилгоор Монгол Улсын иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, хоёр улсад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн

⁵ Global overview of international social security agreements, International Social Security Association, Geneva, 2022

⁶ International social security agreements in Asia-Pacific, International Social Security Association, 2024

тооцуулж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг тогтоолгон авах хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлж, тухайн хүний нийгмийн хамгааллыг баталгааг хангах зорилтыг дэвшүүлнэ.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ

3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд

Хүснэгт № 1. Асуудлыг зохицуулах хувилбарын тайлбар

№	Хувилбарууд	Сонгох эсэх	Тайлбар
1.	"Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:	Үгүй	Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж байгаа Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар одоогийн үүсээд байгаа асуудлыг шийдвэрлэх боломжгүй буюу дээрх хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулна. Тиймээс зохицуулалт хийхгүй орхивол дээр дурдсан зорилгыг хэрэгжүүлж чадахгүй тул "тэг" хувилбар сонгох боломжгүй байна.
2.	Хэвлэл, мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх:	Үгүй	Тулгамдаж байгаа асуудал, хэрэгжүүлэх зорилго, зорилт нь хэвлэл, мэдээлэл, бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлснээр хэрэгжих боломжгүй тул энэ хувилбарыг сонгох боломжгүй.
3.	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх:	Үгүй	Нийгмийн даатгалын харилцаа нь даатгуулагч төвтэй, үүнд ажил олгогч болон төрөөс зарим талаар холбоотой оролцож, хүний амьдралын богино, дунд, урт хугацаанд тохиолдож болох эрсдэлээс үүдэлтэй орлогын бууралтаас хамгаалах нийгмийн үйл ажиллагаа тул зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх хувилбарыг сонгох боломжгүй байна.
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх:	Үгүй	Төрөөс санхүүгийн интервенц хийх замаар тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй.
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх:	Үгүй	Нийгмийн даатгалын цогц харилцааг хэрэгжүүлэх зарим асуудлаар төрийн бус байгууллага, хувийн хэвслийн оролцоо байх боловч энэ хувилбарыг дангаар сонгох байдлаар тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд энэ хувилбар боломжгүй юм.
6.	Захиргааны шийдвэр гаргах:	Үгүй	Тулгарч байгаа асуудлууд, тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах шаардлагатай хэдий ч энэ гаргах эрхийг хуулиар тодорхой зааж олгох шаардлагатай тул бүрэн зохицуулах боломжгүй.
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах:	Тийм	Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах замаар тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх боломжтой.

Дээрх хувилбаруудыг нягталж үзэхэд "Тэг" хувилбар, хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх хувилбар, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс

зохицуулалт хийх хувилбар, төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх хувилбарууд үр дүнгүй болох нь харагдлаа. Иймд асуудлуудыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбараар шийдвэрлэх нь зорилгод хүрэх хамгийн үр нөлөөтэй хувилбар гэж үзлээ.

3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан тухай

Захиргааны шийдвэр гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулсан харьцуулалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт № 2. Хувилбарын харьцуулалт

Сонгож авсан хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Тэтгэврийн даатгалын сангаас даатгуулагчид олгох өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Хууль хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын байгууллагад тодорхой зардал гарах боловч тэтгэвэр тогтоолгогч иргэдэд, үйлчилгээ түргэн шуурхай болж, тэтгэвэр авагчийг эрсдэлээс хамгаалах боломж бүрдэнэ.	Үр дүнтэй гэж дүгнэж байна.

3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарыг сонгох

Сонгогдсон хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан судлахад, хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хамгийн үр дүнтэй хувилбар болох нь харагдаж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААР

Сонгосон хувилбарын үр нөлөөг Аргачлалын 6.2-т заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын хувьд хүний эрхийг хууль бусаар хязгаарлах, ялгаварлан гадуурхах зэрэг хүний эрхийн зөрчлийг агуулаагүй гэж дүгнэж байна. Харин Үндсэн хуульд заасан өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг хангахад чиглэгдсэн байна.

Хүснэгт № 3. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний тайлбар

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Хүний	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		

эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж хүн бүрт эрх тэгш байдлыг бий болгоно.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын иргэдийг хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд харилцан тэгш эрхтэй хамрагдаж, хууль тогтоомжид заасан нөхцөлийг хангасан бол тэтгэвэр авах боломжтой.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх		Үгүй	Нийгмийн даатгалын харилцаа нь зөвхөн тодорхой нэг эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ биш юм.
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Энэхүү хууль нь хоёр улсын иргэдэд ижил тэгш үйлчлэх зарчим дээр үндэслэх тул хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, өндөр настай хүмүүсийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн харилцаан дахь тэтгэврийн нөхцөлийг сайжруулах зэрэг асуудлууд хөндөгдсөн бөгөөд эдгээр зохицуулалтууд нь олон улсын болон үндэсний хэм хэмжээнүүдэд нийцсэн байна.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Хуулийн төсөл батлагдсанаар хоёр улсын иргэдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдал бий болохгүй. Харин тэтгэврийн уян хатан нөхцөлөөр тогтоолгох, иргэнд түргэн шуурхай хүргэх боломж бүрдэнэ.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Хуулийн төсөлд хоёр улсад ажил хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хүн бүр хамрагдах боломж бүрдсэнээр тэдгээрийн нийгмийн баталгаа хангагдана. Энэхүү харилцаанд ямар нэгэн ялгаварлан гадуурхах, давуу байдлыг бий болгох зохицуулалт тусгагдаагүй болно. Түүнчлэн тухайн хүн хоёр улсад ажилласан, даатгуулсан цаг хугацааны хувьд давхардаагүй хугацаагаа нэгтгэн тооцуулж, тэтгэвэр тогтоолгох эрхтэй болж хөдөлмөрлөсөн хөдөлмөрийн үр шимийг дээд зэргээр хүртэх, өндөр наслахад нийгмийн баталгааг нь хангах боломжийг бий болгох юм.

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 1952 онд батлан гаргасан “Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай” 102 дугаар конвенцод ⁷ дурдсан нийгмийн хамгааллын доод хэмжээний зөвлөмжтэй нийцэж байгаа болно.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		Хоёр улсын хууль тогтоомжийн дагуу хуулийн нөхцөл, шаардлагыг хангаагүй хүнд тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх боломжгүй, мөн хуулийн төсөлд заасан хэлэлцээрийг тайлбарлах ба хэрэглэхтэй холбоотой маргааныг талууд зөвлөлдөх, хэлэлцэх замаар шийдвэрлэнэ талаар тусгасан болно.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	Хуулиар хүний эрхийг хязгаарлаагүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Хуулиар хүний эрхийг хязгаарлаагүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		Хоёр улсын Засгийн газар, холбогдох төрийн байгууллага, хөдөлмөр эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, өндөр настан зэргийн нийгмийн даатгалын харилцаанд хэрхэн оролцох эсэхийг тодорхойлно.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм		Хэлэлцээрийн хүрээнд бүрэн эрхт байгууллага, эрх бүхий байгууллагыг тодорхойлж хамтын ажиллагааны хүрээнд иргэдийн тэтгэвэр тогтоох харилцааг тодорхойлсон.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		Хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдсан иргэдийн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход ажилласан, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож, тэтгэврийн эрх үүсгэх боломжтой эрх зүйн байдлыг дээрдүүлсэн мөн нийгмийн баталгаа нь хангагдах юм.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Үгүй	Хүн бүр тэгш эрхтэй оролцоно.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Хоёр улсын Засгийн газар, холбогдох төрийн байгууллагууд, иргэд нь хуулиар тогтоох болон тухайн улсын

⁷ ОУХБ “ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл” УБ 2012, 330 дугаар тал

				хууль тогтоомжийн харилцаанд үүрэг хүлээнэ.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Хүйсээр ялгаварлахыг хориглох агуулга хүний эрхийн ерөнхий зарчмын хүрээнд тусгагдана.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Хоёр улсад нийгмийн хамгааллын болон тэтгэвэртэй холбоотой харилцаанд хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбар нь даатгуулагч иргэн, ажил олгогч, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт зардал үүсгэхгүй харин төрийн байгууллагын (нийгмийн даатгалын байгууллага) хувьд бага хэмжээний үйл ажиллагааны зардал болон ажлын ачаалал нэмэгдэхээр байна.

Гэвч энэхүү ачаалал нь Бүгд Найрамдах Австри Улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн тэтгэвэр авах эрхийг хангахад чиглэгдэж байна.

Иймд энэхүү зохицуулалт нь асуудал хариуцсан төрийн байгууллагын чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт бий болгохгүй, харин үйл явцыг илүү тодорхой, ил тод болгоно.

Хүснэгт № 4. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний тайлбар

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуудлууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

зардал	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Иргэнд нийгмийн шинжтэй эрсдэл тохиолдсон бол урт хугацаанд санхүүгийн эерэг нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт		Үгүй	Нийгмийн даатгал хариуцсан төрийн байгууллага одоогийн

	хийх шаардлага тавигдах эсэх			бүтцээрээ боломжтой.	ажиллах
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Нийгмийн хариуцсан байгууллага бүтцээрээ боломжтой	даатгал төрийн одоогийн ажиллах
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ажил эрхлэлтийг дэмжиж, тэтгэврийн нэмэлт орлого бий болсноор эдийн засагт нөлөөлөх боломжтой.	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.	
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.	

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбар нь хүн амын нийгмийн хамгааллын баталгааг хангахад эергээр нөлөөлнө. Хувилбарыг хэрэгжүүлэх нь тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх, илүү үр дүнг бий болгох магадлалтай байна.

Хүснэгт № 5. Нийгэм үзүүлэх нөлөөний тайлбар

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Бүгд Найрамдах Австри Улсад албан ёсоор болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэд хоёр улсын нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдах боломж бүрдсэнээр тэдгээрийн ирээдүйн нийгмийн баталгаа хангагдах эерэг нөлөөтэй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Хоёр улсад хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн ирээдүйн нийгмийн баталгаа нь хангагдах тул тогтвортой ажиллахад нь эерэг нөлөө үзүүлнэ.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуу-дын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн, хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээ-ний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Харин нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай авах боломж бүрдэнэ.

	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй Байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын овийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Хүснэгт № 6. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний тайлбар

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл (Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ)-ийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Амьдралын чанар ба дундаж давхарга” хэсгийн зорилт 3.1-т “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, мөн зорилтыг хэрэгжүүлэх I үе шатанд “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ” “Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.6-д “Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах” зорилт дэвшүүлсэн.

Иймд дээрх хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 1952 онд батлан гаргасан “Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай” 102 дугаар конвенцтой⁸ нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, хууль тэгшээр үйлчлэх зарчимд бүрэн нийцэж байгаа болно.

⁸ ОУХБ “ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл” УБ 2012, 330 дугаар тал

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хуулийн төсөл боловсруулах хувилбарын эерэг болон сөрөг талуудыг:

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар нягтлан үзэхэд тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэлээ.

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Олон улсын нийгмийн хамгааллын холбооноос гаргасан “Нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүд” удирдамжид нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдахад хүндрэлтэй байгаа шилжин суурьшигч, тэдний гэр бүл зэрэг тодорхой бүлгийн иргэдийг хоёр болон олон талт нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах замаар хамруулах талаар тусгасан байна.⁹

Түүнчлэн Олон улсын нийгмийн хамгааллын холбооноос 2024 онд хийсэн “Ази, Номхон далайн бүс нутаг дахь нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээр”-ийн үнэлгээнд олон улсын нийт шилжин суурьшигчдын гуравны нэг нь тус бүс нутгаас гаралтай байгаа нь дэлхийн хэмжээнд хамгийн их шилжин суурьшигчтэй бүс нутаг байна. Тиймээс эдгээр бүс нутгийн Засгийн газрууд шилжин суурьшигч иргэдийнхээ нийгмийн хамгааллыг эрхийг хангах, сайжруулахад ихээхэн анхаарч, нэг талт болон олон талт нийгмийн хамгааллын хэлэлцээрийг байгуулан хэрэгжүүлж байна.¹⁰ Үүнд:

Зураг 1. Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээр байгуулсан бүс нутгийн улс орон, гэрээний төрөл, эзлэх хувиар


Бүс нутгийн улс орнууд	Аль нэг төрлийн хэлэлцээр	Хоёр талт хэлэлцээр	Олон талт хэлэлцээр
Ази-Номхон далайн орнууд	43	25	18
Европын орнууд	100	95	77
Африкийн орнууд	61	41	41
Америкийн орнууд	88	73	59
Нийт	74	59	48

Дэлхий нийтээр 1970-аад оноос хойш хоёр талт нийгмийн хамгааллын хэлэлцээрийн тоо хурдацтай өсч, 1980-аад оноос хойш Ази-Номхон далайн орнуудын оролцоо илүү өсөж байна.

⁹ Олон улсын нийгмийн хамгааллын холбооны удирдамж “Нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүд”, 2022 он

¹⁰ International social security agreements in Asia-Pacific. International Social Security Association, 2024


Зураг 2. Хоёр талт нийгмийн хамгааллын хэлэлцээрийн тоо, бүс нутгаар (нэг эсвэл хоёр тал)



Ази-Номхон далайн бүс нутгийн тухайд Бүгд Найрамдах Солонгос Улс 39, Австрали 31, Япон 22, Энэтхэг 19, Филиппин 14, Хятад 11, Шинэ-Зеланд 9, Монгол Улс 6 улстай тус тус хэлэлцээр байгуулан хэрэгжүүлж байна. Доорх зургаас харахад 2010 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг тоо эрчимтэй өсчээ.

Зураг 3. Хоёр талт нийгмийн хамгааллын хэлэлцээрийн нийт тоо, хэлэлцэн тохиролцогч талаар¹¹

¹¹ International social security agreements in Asia-Pacific, International Social Security Association, 2024



Дэлхийн хэмжээнд нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрт тэтгэвэр (өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсан болон тэжээгчээ алдсаны)-тэй холбоотой зохицуулалтыг илүү авч үзэж байна. Тухайлбал, хоёр тал хэлэлцээр байгуулж байгаа Ази-Номхон далайн улс орнуудын 80 орчим хувь нь хоёр улсад ажилласан, даатгуулсан хугацааг нэгтгэн тооцож, тэтгэвэр тогтоох харилцааг зохицуулжээ. Харин дэлхий нийтийн олон улсын хэлэлцээрийн 90 гаруй хувь нь тэтгэвэр, 60 орчим хувь нь бусад тэтгэмж, ажлын байрны осол, гэмтлээс шалтгаалсан, тэтгэвэр, тэтгэмж, 24 орчим хувь нь эрүүл мэндийн болон ажилгүйдлийн тэтгэмжийн зохицуулалтыг тусгасан байна.¹²

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү тандан судалгаагаар “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж, батлах нь зүйтэй гэж дүгнэж байна. Ингэснээр Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын иргэд хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд харилцан тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх ба цаашлаад нийгмийн хамгааллын баталгааг хангах эрх зүйн үндэс бүрдэнэ гэж үзэж үзлээ.

¹² McAuliffe, M. and L.A. Oucho (eds.), 2024. World Migration Report 2024. International Organization for Migration (IOM), Geneva.

АШИГЛАСАН ГАРЫН АВЛАГА, СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ

Гарын авлага, судалгааны материал:

1. McAuliffe, M. and L.A. Oucho (eds.), 2024. World Migration Report 2024. International Organization for Migration (IOM), Geneva.
2. “Диаспорт чиглэсэн бодлого” бодлогын суурь судалгаа, НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, 2024 он
3. “Монгол Улсын иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн ба гадаад хувийн шилжүүлэг, тэдгээрийн үр нөлөө” судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, 2023 он
4. Global overview of international social security agreements, International Social Security Association, Geneva, 2022
5. International social security agreements in Asia-Pacific, International Social Security Association, 2024
6. ОУХБ “ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл” УБ 2012, 330 дугаар тал
7. Олон улсын нийгмийн хамгааллын холбооны удирдамж “Нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүд”, 2022 он

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүд:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
4. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого УИХ-ын тогтоол 2020.05.13 №52
5. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр УИХ-ын тогтоол 2024.08.27 №21

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС
БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Нэг. Ерөнхий зүйл

Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон байдал

Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа

Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасан анхдагч хуулийн төслийн төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр (Хэлэлцээр)-ийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төслийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд соёрхон батлах Хэлэлцээрт туссан дараах зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжийг шалгахар сонгож авав. Үүнд:

- Хэлэлцээрийн хүрээнд нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлсэн нь хэрэгжүүлэгч субъект /нийгмийн даатгалын байгууллага, байцаагч/-д ачаалал, бэрхшээл учруулах эсэх, хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт зардал гарах эсэхийг үнэлэх;
- Хэлэлцээрт туссан зохицуулалтууд нь хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцид нийцэж байгаа эсэхийг;
- Хэлэлцэн тохиролцогч талуудад тэтгэвэр тогтоохтой холбоотой зохицуулалт нь хоёр улсын иргэдийн харилцан тэгш эрхтэй байдлыг тусгасан эсэхийг үнэлэх;
- Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд хүний хувийн мэдээллийг дамжуулах, солилцох зохицуулалтыг үнэлэх /16 дугаар зүйл/.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг үнэлэхийг зорив.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөсөн зохицуулалттай холбогдон гарах тооцоолол хийх мөн “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хэлэлцээр, хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төсөл нь “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, хоёр улсад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн

хугацаанд ногдох тэтгэврийг тогтоолгон авах эрх зүйн үндсийг тодорхойлох зорилгоор дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах;

2. Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад томилолтоор ажиллагч нь шимтгэл давхар төлөхөөс сэргийлэх;

3. Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох боломжийг бүрдүүлэх;

4. Хэлэлцэн тохиролцогч талууд тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг зохицуулах.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үнэлэхэд:

Зорилт 1. *Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах талаар:*

Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн тоо 2023 оны байдлаар 210.0² мянга буюу нийт хүн амын 6.1 хувь байгаагаас 110.0 мянга нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Иймд одоогийн нийгмийн даатгалын тогтолцооны хамрах хүрээнээс гадуур байгаа эдгээр иргэдийг нийгмийн даатгалд хамруулах тусгайлсан зохицуулалтыг хуулиар зохицуулах шаардлагатай байгаа тул хуулийн төсөлд хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

Зорилт 2. *Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл давхар төлөхөөс сэргийлэх талаар:*

Богино хугацаагаар ажиллагч иргэд Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийн хүрээнд хоёр улсад давхар шимтгэл төлөөс сэргийлэх зохицуулалтыг хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

Зорилт 3. *Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох боломжийг бүрдүүлэх талаар:*

Тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн иргэд Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийн хүрээнд ямар тэтгэврийн төрөлд хамрагдахыг тодорхой болгох, ямар хугацааны шимтгэл төлсөн хугацааг тооцох зохицуулалтыг хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

Зорилт 4. *Хэлэлцэн тохиролцогч талууд тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг зохицуулах талаар*

Хэлэлцэн тохиролцогч талуудад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэврийг хэрхэн тогтоох, олгох харилцааг тодорхой болгох зохицуулалтыг хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

² Гадаад харилцааны яамны Консулын газрын мэдээлэл

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, Сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох
2	Практикт хэрэгжих боломж	Хэлэлцээрийн 2, 4, 14, 15, 16, 17, 18, 19 дугаар зүйл	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх. Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) эсэхийг судалж тодорхойлох
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Зардал	“Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоо хийх	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардлын тооцоо хийх /аргачлалын дагуу тусад нь хийх/
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зарим хэсэг	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдааг холбох

Дээрх шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилт 1. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах талаар үнэлгээ хийсэн нь:

Монгол Улсын өнөөгийн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэд өөрийн улсынхаа нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах боломжтой хэдий ч тухайн амьдарч буй улсдаа давхар шимтгэл төлөх, шимтгэл төлсөн хугацаа нь Монгол Улсад даатгуулсан хугацаанд тооцогдохгүй нөхцөл байдал үүсэж байна. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэд тухайн улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдахад иргэний харьяаллын шаардлага, тэтгэвэр, тэтгэмж авах хууль тогтоомжид заасан хугацааны нөхцөл хангахгүйд хүрч нийгмийн хамгааллын баталгаа нь алдагдах,

мөн тухайн улс болон өөрийн улсдаа нийгмийн даатгалын шимтгэлийг давхар төлж санхүүгийн ачаалалд орох зэрэг бэрхшээлүүд тулгарч байна.

Энэ нь иргэд ирээдүйд бага тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн эрх үүсэхгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тиймээс Хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн хүрээнд хэлэлцэн тохиролцогч талуудын иргэд хоёр улсад ажилласан (даатгуулсан) хугацаагаа нэгтгэн тооцуулж, тэтгэвэр тогтоолгон авах зэрэг зохицуулалтыг тусгасан нь хоёр улсын иргэдийн ирээдүйн нийгмийн хамгааллын баталгааг хангахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Зорилт 2. *Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл давхар төлөхөөс сэргийлэх талаарх үнэлгээ:*

Хэлэлцэн тохиролцогч нэг талаас хэлэлцэн тохиролцогч нөгөө талд томилолтоор эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол зөвхөн эхний талдаа буюу өөрийн улсдаа шимтгэл төлөх харилцааг зохицуулсан байна. Энэхүү харилцааг Хэлэлцээрийн 6, 7, 8 дугаар зүйлд нарийвчлан заажээ. Тухайлбал, 6 дугаар зүйлд Ерөнхий заалтыг, 7 дугаар зүйлд Тусгай заалтууд буюу 1-60 хүртэл хугацаанд хэлэлцэн тохиролцогч нөгөө талд томилолтоор эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол давхар шимтгэл төлөхөөр сэргийлсэн зохицуулалтыг тусгасан байна.

Зорилт 3. *Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох боломжийг бүрдүүлсэн байдлын үнэлгээ:*

Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомж, тэтгэврийн тогтолцооны онцлогоос хамааруулж тэтгэврийн төрлийг сонгож, хоёр улсад шимтгэл төлсөн цаг хугацааны хувьд давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож байж тэтгэвэр тогтоохоор зохицуулсан байна.

Тухайлбал, Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд тэтгэврийн төрлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Энэхүү Хэлэлцээрт дараах хууль тогтоомж хамаарна:

а) Монгол Улсын тухайд:

Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн асуудлаарх хууль тогтоомж;

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн асуудлаарх хууль тогтоомж;

б) Бүгд Найрамдах Австри Улсын тухайд:

Нотариатчидын онцгой хамгааллаас бусад тэтгэврийн даатгалын асуудлаарх хууль тогтоомж;

Зөвхөн II бүлгийн тухайд, өвчний даатгал болон ослын даатгалын асуудлаарх хууль тогтоомж.

Мөн Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох харилцааг зохицуулжээ. Үүнд:

1.Хэрэв тухайн хүн Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацаатай бол тэтгэмж авах эрхийг тодорхойлох зорилгоор шаардлагатай тохиолдолд эрх тодорхойлох Хэлэлцэн

тохиролцогч тал нь эдгээр хугацааг өөрийн талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаа мэтээр нэгтгэн тооцно.

2.Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тусгай схемийн хүрээнд тодорхой мэргэжлийн төрөлд, эсхүл тухайлсан ажил, хөдөлмөр эрхлэлтэд даатгалын шимтгэл төлсөн хугацааг харгалзан тэтгэмж олгодог бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу зөвхөн ижил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд даатгалын шимтгэл төлсөн хугацааг тухайн тэтгэмжийг олгохдоо харгалзан үзнэ.

3.Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь нийгмийн хамгааллын тухай ижил төрлийн хэлэлцээр байгуулсан гуравдагч улсад даатгалын шимтгэл төлсөн хугацааг зөвхөн Хэлэлцэн тохиролцогч тухайн тал нь тэтгэвэр олгох эрхийг тодорхойлох зорилгоор харгалзан үзнэ.

4.Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн төлбөрийг олгосон хугацаа нь даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг уртасгахаар заасан тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авсан хугацаагаар дээр дурдсан даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг уртасгана.

Зорилт 4. *Хэлэлцэн тохиролцогч талууд тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг зохицуулах талаар үнэлгээ хийсэн нь:*

Хэлэлцээрийн 10, 11 дүгээр зүйлд Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоох, 14-23 дугаар зүйлд Хэлэлцээрийн хүрээнд тэтгэврийг олгохтой холбоотой талуудын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан мэдээлэл солилцохоор зохицуулсан нь зорилгоо илэрхийлсэн гэж үнэллээ.

2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

1/ *Хэлэлцээрт нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлсэн нь хэрэгжүүлэгч субъект /нийгмийн даатгалын байгууллага, байцаагч/-д ачаалал, бэрхшээл учруулах эсэх, хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт зардлын үнэлгээ*

Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас олгох жилд дунджаар 20 орчим мянган хүн тэтгэвэр тогтоолгож байна. Бүгд Найрамдах Австри Улсад 2024 оны байдлаар Монгол Улсын 3000 орчим иргэн оршин сууж байгаагаас 1.7 мянга иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Монгол Улсад Бүгд Найрамдах Австри Улсын 30 орчим иргэн оршин сууж байна. Мөн Хэлэлцээрийг хэрэгжүүлэгч Нийгмийн даатгалын байгууллагад улсын хэмжээнд 1.5 мянган албан хаагч ажиллаж байна. Тиймээс Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсад тэтгэвэр тогтооход нийгмийн даатгалын байгууллага, байцаагчид ачаалал үүсэхгүй бөгөөд Хэлэлцээрийг Бүгд Найрамдах Австри Улсад ажилласан жилийг баталгаажуулахад шаардлагатай шуудангийн зардлаас өөр нэмэлт зардал гаргахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой.

2/ *Хэлэлцээрт туссан зохицуулалтууд нь хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцид нийцэж байгаа эсэх үнэлгээ*

Хэлэлцээрийн хүрээнд тэтгэвэр тогтоох харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон Монгол Улсад шимтгэл төлөх харилцааг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

Хэлэлцээрт туссан зохицуулалтууд нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 1952 онд батлан гаргасан “Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай” 102 дугаар конвенцод³ дурдсан нийгмийн хамгааллын доод хэмжээний зөвлөмжтэй нийцэж байгаа болно.

Түүнчлэн Хэлэлцээр нь 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц болон 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцийн холбогдох заалтад нөлөөлөхгүй.

3/ Хэлэлцэн тохиролцогч талуудад тэтгэвэр тогтоохтой холбоотой зохицуулалт нь хоёр улсын иргэдийн харилцан тэгш эрхтэй байдлыг тусгасан эсэх үнэлгээ

Хэлэлцээрт талуудын иргэдийн эрх тэгш байдлыг хангах зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал, хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэд, хамаарал бүхий хүмүүс болон тэжээгчээ алдагчдад Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү Хэлэлцэн тохиролцогч талын иргэний адил эрх тэгш хандахаар тусгасан байна.

Хэлэлцээрийн 14 дүгээр зүйлд бүрэн эрх бүхий этгээдүүдийн хамтын ажиллагаа, захиргааны дэмжлэгийн асуудлын хүрээнд Удирдлагын тохиролцоо байгуулахаар тусгасан нь хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад үүсгэх аливаа асуудлыг шийдэх, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн Хэлэлцээрийн 15 дугаар зүйлд Захиргааны болон эрх зүйн туслалцаа, 16 дугаар зүйлд Мэдээлэл хамгаалал, 17 дугаар зүйлд Төлбөр ба баталгаажуулалтаас чөлөөлөх, 18 дугаар зүйлд Өргөдөл, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг эрх тэгш авч үзэх, 19 дүгээр зүйлд Эмнэлгийн үзлэг, 20 дугаар зүйлд талуудын харилцах хэлийг найрийвчлан тусгасан нь хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэх эерэг нөлөөтэй.

4/ Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд хүний хувийн мэдээллийг дамжуулах, солилцох зохицуулалтын үнэлгээ

Хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохиролцогч талуудын нутаг дэвсгэрт шимтгэл төлсөн хугацааг иргэний өөрийн хүсэлтэд үндэслэн маягтуудын дагуу солилцох тул Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцэх юм.

Мөн хэлэлцээрийн 16 дугаар зүйлд Мэдээллийн хамгаалал нь хувь хүний нууцад хамаарах, мэдээллийг зөвхөн шаардлагатай тохиолдолд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор хэлэлцэн тохиролцогч талууд хувь хүний мэдээллийг харилцан солилцож болно. Хувь хүний мэдээллийг харилцан солилцох болон боловсруулалт хийхдээ дотоодын холбогдох хууль тогтоомж болон мэдээлэл солилцож байгаа байгууллагуудын гаргасан нөхцөл шаардлагыг баримтлахаар зааж, талуудын улсын хууль тогтоомжийн хүрээнд ашиглахаар зохицуулсан.

3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

³ ОУХБ “ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл” УБ 2012, 330 дугаар тал

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23.1 дэх хэсэгт зааснаар тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг хянах байдлаар үнэлгээ хийлээ.

Хэлэлцээр нь нийтдээ 5 бүлэг, 26 зүйлтэй, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Шаардлага хангасан.
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зорчсон этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Шаардлага хангасан.
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Шаардлагагүй.

29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

4.“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг хавсаргав.

5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасны дагуу хуулийн төслийн уялдаа холбоог дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасан Хуулийн төслийн уялдаа холбоог тогтооход тавих нийтлэг шаардлага	
<i>Шаардлага</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	-
4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	үгүй
4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	тийм
4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	үгүй
4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	үгүй
4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	үгүй
4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай

ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	үгүй
4.10.13.хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
4.10.14.хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.16.хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	тийм

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Дүгнэлт

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд, зорилт 1-ээс 4-ийг хангахад чиглэгдсэн зохицуулалтууд нь зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон байна.
- Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг судлахдаа хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийхэд хуулийн төслийг ойлгомжтой болгох чиглэлээр санал ирүүлээгүй байна.
- Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.
- Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан.

--- оОо ---



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД
НАЙРАМДАХ АВСТРИ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НЭМЭГДЭЖ ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу тооцлоо.

Зардал тооцсон субъект:

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн зорилт нь гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг сайжруулах хүрээнд иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, хоёр улсад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг тогтоолгон авах харилцааг тодорхойлоход оршиж байгаа тул хуулийн төслийн улсын төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагч, төрийн байгууллагад үзүүлэх нөлөөллийн зардлыг тооцов.

I. УЛСЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын сангийн орлогод нөлөө үзүүлэхгүй. Харин нийгмийн даатгалын сангийн зардалд дараах нөлөө үзүүлэхээр байна. Үүнд:

Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэв тухайн хүн Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацаатай бол тэтгэмж авах эрхийг тодорхойлох зорилгоор шаардлагатай тохиолдолд эрх тодорхойлох Хэлэлцэн тохиролцогч тал нь эдгээр хугацааг өөрийн талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаа мэтээр нэгтгэн тооцно.” гэж заасан. Түүнчлэн, Хэлэлцээрийн 12 болон 13 дугаар зүйлд Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцсоны дараа тухайн улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийг тооцоолж олгохоор заасан. Ингэхдээ шимтгэл төлсөн нийт хугацаанаас тухайн улсад шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг олгох зохицуулалтыг тусгасан. Үүнтэй холбоотойгоор Хэлэлцээрийн хүрээнд тэтгэврийн даатгалын сангаас тэтгэврийн зардал гарна.

Тухайлбал, Монгол Улсын иргэн өөрийн улсдаа 12 жил, Австри Улсад 13 жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, хоёр улсын тэтгэврийн насанд хүрсэн гэвэл хоёр улсад шимтгэл төлсөн хугацаагаа нэгтгэн 25 жилээр тооцуулж, тэтгэврийн эрх үүсгэх бөгөөд Монгол Улсаас шимтгэл төлсөн 12 жилд ногдох тэтгэврийг, Австри Улсаас 13 жилд ногдох тэтгэврийг тус тус тогтоолгох авах боломжтой болно.

2024 оны байдлаар Бүгд Найрамдах Австри Улсад Монгол Улсын 2,668 иргэн оршин сууж байгаагаас 1,696 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны мэдээллээр Монгол Улсад БНАУ-ын 30 орчим иргэн оршин сууж байна.

Хэлэлцээр хэрэгжсэнээр нийгмийн даатгалын сангаас зардал гарах боловч иргэдийн нийгмийн хамгааллын баталгаа нь сайжрах эерэг нөлөөтэй.

Харин хэлэлцээргүй нөхцөлд тухайн иргэн хоёр улсын хуулийн дагуу тэтгэвэр авахад шимтгэл төлсөн байх хугацаа, нас, иргэний харьяаллын шаардлагыг хангахгүй нөхцөлд нийгмийн хамгааллын баталгаа нь алдагдах эрсдэлтэй бөгөөд ингэснээр улсын төсвөөс буюу нийгмийн халамжийн сангаас насан туршдаа тэтгэвэр авах нөхцөл үүсэх юм.

II. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хүрээнд ажил олгогчид нэмэлт зардал үүсгэх хуулийн зохицуулалт ороогүй болно. Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан шинээр ажлын байр нэмэгдэхгүй юм.

III. ИРГЭН /ДААТГУУЛАГЧ/-Д ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хүрээнд даатгуулагчид нэмэлт зардал үүсгэх хуулийн зохицуулалт ороогүй болно.

IV. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хэлэлцээрт иргэнээс тэтгэвэр тогтоолгох өргөдөл хүлээн авах, ажилласан, шимтгэл төлсөн хугацаа баталгаажуулах, тэтгэвэр шилжүүлэхтэй холбоотой дараах зохицуулалт туссан бөгөөд зардлыг дараах байдлаар тооцлоо. Үүнд:

Тэтгэвэр тогтоохтой холбоотой зардал

Хэлэлцээрийн 9 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 2-т “Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу гаргасан тэтгэмж авах хүсэлт нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу тухайн тэтгэмжийг авах хүсэлтийн нэгэн адилаар тооцогдоно. Хүсэлтэд Хэлэлцэн тохиолцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааны талаарх мэдээллийг тусгасан байна.” гэж тус тус заасантай холбогдуулан дараах тооцоог хийв.

Монгол Улсын тухайд хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ) бөгөөд гадаад хамтын ажиллагаа, нийгмийн хамгааллын хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтэн ажиллаж байна. Иймээс НДЕГ-ын хувьд хүний нөөцийн нэмэлт зардал шаардагдахгүй буюу хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан шинээр ажлын байр нэмэгдэхгүй юм.

Харин хэлэлцээрийн хүрээнд иргэн тэтгэвэр тогтоолгох ажилласан жилээ баталгаажуулах өргөдлийг НДЕГ-т гаргах бөгөөд тус газар нь иргэний Бүгд Найрамдах Австри Улсад ажилласан, даатгуулсан хугацааг баталгаажуулах зорилгоор тус улсын эрх бүхий байгууллагад иргэний баримт бичгийн хуулбарлан явуулах, эсхүл БНАУ-аас ирүүлсэн мөн ажилласан, даатгуулсан жилийг баталгаажуулах хүсэлтийн хариуг илгээхтэй холбоотой зардал гарна. Тиймээс

тэтгэвэр тогтоолгох өргөдлийг НДЕГ-т гаргасан иргэний баримт бичгийг шалгах, ажилласан, даатгуулсан хугацааг баталгаажуулахтай холбоотой гарах бичиг хэрэг, шуудангийн зардлын тооцоо хийлээ. Үүнд:

№	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Хугацаа (минут)	Бичиг хэргийн зардал (төгрөг)
1.	Үүрэгтэй танилцах	5	-
2.	“Бүгд Найрамдах Австри Улсын нутаг дэвсгэрт оршин сууж шимтгэл төлсөн хугацааг баталгаажуулах хүсэлт” маягт хэвлэх зардал (5 нүүр)	3	40₮ x 2 ш + 93₮ x 5 нүүр = 545₮
3.	Өргөдөл гаргасан иргэний ажилласан хугацааг тооцоолох, Мэдээллийн технологийн нэгжээс мэдээллийг нягтлах	8	-
4.	Иргэний тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг хуулбарлах (~10 нүүр)	5	40₮ x 10 ш + 93₮ x 10 нүүр = 1330₮
5.	Албан бичиг боловсруулах (1 нүүр)	10	40₮ x 1 ш + 93₮ x 1 нүүр = 133₮
6.	БНАУ-ны эрх бүхий байгууллагад илгээх шуудангийн зардал	6	30гр = 5,600 ¹ төгрөг
Нэг тохиолдлыг шийдвэрлэх хугацаа, зардал		36 минут	7,608 төгрөг
		36 мин x 160.32₮ ² = 5,772₮	

Тайлбар: Бичгийн цаас³, принтерийн хорны⁴ зардлаар тооцов.

Талуудын эрх бүхий байгууллагууд нь иргэний тэтгэвэр тогтоохтой холбоотой мэдээллийг цахим хэлбэрээр солилцох боломжтой. Тиймээс нэг иргэний тэтгэвэр тогтоолгох өргөдлийг шийдвэрлэхтэй холбоотой 7,608 төгрөгийн бичиг хэргийн зардал нь зөвхөн шаардлагатай тохиолдолд гарах юм.

Мөн НДЕГ-т хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ ажлын байр бий болохгүй, орон тоо нэмэхгүй учир 5,772 төгрөгийн цалингийн зардал нэмж гарахгүй юм.

---oOo---

¹ Монгол шуудан ХК-ны гадаад шуудангийн тарифаар тооцов, <https://www.mongolpost.mn/price-calc>

² Засгийн газрын агентлагийн ТЗ-6 шатлалын цалин 1,693,000₮, <https://egalinfo.mn/mn/detail?lawid=17355342377571&showType=1>

³ Цагаан өнгийн А4 хэмжээ 500 ширхэгтэй бичгийн цаас, үнэ 20,280₮, <https://nom.in.mn/v/19469/19515/27124>

⁴ Принтерийн хор (HP LaserJet 125A) 1400 хуудас хэвлэх, үнэ 129,900₮, <https://bsb.mn/products/by-code/HP-CB543A-M>

АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

(УИХ-ын чуулган болон Байнгын хорооны хуралдаанд оролцох)

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс
хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх

№	Овог, нэр	Албан тушаал	Утасны дугаар
1.	Тилеуханы Аубакир	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	9911-4595
2.	Лхагвасүрэнгийн Мөнхзул	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн дарга	9909-8704
3.	Ванчингийн Рэнцэнханд	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга	9910-8453
4.	Цэнд-Аюушийн Ганцэцэг	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга	9929-3440